

**Статистикийн хэлтсийн 4 дүгээр сарын 01-нээс 4 дүгээр сарын
04-ний өдрийг хүртлэх 5 хоногт хийсэн ажлын товч мэдээ**

2019.04.04

Өлгий хот

1. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд ХАӨМС-ийн тодруулгыг хийж байгаа, сумдын санхүү, төрийн сангийн төлөөлөгч, багийн Засаг дарга нарт зааварчилгаа өгч, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Мөн Алтанцөгц сумын Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн болон 2 дугаар багийн Засаг даргын компьютерыг форматалж, ХАӨМСангийн программ суулгаж өгөв.
2. Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн Төрийн бус байгууллага, барилга, аж үйлдвэр, зочид буудал, зоогийн газар, тээвэр, холбоо, Хөдөө аж ахуй, ан агнуур, загас агнуур, ойн аж ахуй, мал эмнэлэг, барьцаалан зээлдүүлэх, мэргэжлийн шинжлэх ухаан, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн жилийн эцсийн тодруулга, лавлагааг хийж холбогдох газарт хүргүүлэв.
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2018 оны гүйцэтгэлийн ХО-3 мэдээг гаргаж бэлэн болгосон.
4. ХО-3 мэдээний 2019 оны 1-р улиралд хүргүүлсэн хүрээнд тодруулга хийв.
5. Хэлтсийн Вэб сайтад хүн амын үзүүлэлтүүдийн 2018 оны болон урьд онуудын 5 төрлийн динамик эгнээ хийж байршуулав.
6. Нийгмийн халамжийн сангийн 4 дүгээр сарын мэдээг бэлтгэж байгаа.
7. Хүнсний гол нэрийн барааны үнийн мэдээг 7 хоног бүрийн лхагва гарагт цуглуулан, төв руу дамжуулав.
8. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон ажиллах хүчний судалгааны мэдээллийг сонгогдсон нэгжээс авч, хянаж хугацаанд нь ҮСХ-нд онлайнаар хүргүүлэв.
9. Хэлтсийн портал сайтанд 7 хоногийн үнийн өөрчлөлтийн мэдээг оруулав.
10. Мал төллөлт, төл бойжилтын мэдээ, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ болон том малын зүй бус хорогдлын мэдээг сумуудаас нэгэтгэн авч, алдаатай мэдээллийг засаж программд оруулав.
11. Статистикийн анхан шатны мэдээллийг гаргадаг сумдын санхүү, төрийн сангийн төлөөлөгч нарт “Статистикийн мэдлэгийг дээшлүүлэх” сэдвээр сургалтыг ҮСХороотой хамтран хийхээр саналаа хүргүүлж байна.
12. ҮСХорооноос зохион байгуулсан хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үйлдвэрлэгчийн үнэ, хөдөө аж ахуйн үнийн тухай тус мэдээнүүдийг хариуцсан ажилтнуудад зориулсан онлайн сургалтад холбогдох мэргэжилтэн болон хэлтсийн дарга оролцов.
13. Үндэсний статистикийн хорооны ажил дүгнэх журмын дагуу хэлтсийн 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт болон байнга, түр хадгалах

хадгаламжийн нэгжийн бүртгэлийг хэлтсийн даргаар батлуулан ҮСХ-ны архив, бичиг хэргийн эрхлэгчид хүргүүлэв.

Статистикийн хэлтэс